ӨМНӨТГӨЛ

Монголын анагаах ухаанд эрдэм бүтээлээрээ тод мөрийг үлдээсэн хорьдугаар зууны шилдэг мэргэдийн нэг нь дотрын хэмээх тодотголтой Эрүүлийг хамгаалахын сайд асан, Монголын цусны эмгэг судлалыг үүсгэн байгуулагч, Монгол Улсын ардын эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, МАУА-ийн үндэслэгч гишүүн, профессор Чойжилжавын Цэрэннадмид юм.

Профессор Ч.Цэрэннадмид нь Монголын уудам хөдөө нутагт эмнэлгийн анхан шатны тусламжийг бага, дунд мэргэжлийн түвшингээс дээд боловсролтой, их эмчийн түвшинд шилжүүлэх, аймгийн төвүүд дэх эмнэлгүүдийг үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үзүүлдэг болгон шинэ шатанд гаргах зэрэг эрүүл мэндийн салбарын нэн чухал хөгжлийн эхлэлийг тавилцаж, энэ салбарыг хөгжүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн түүхэн гавьяатан төдийгүй эрүүл мэндийн бүх шатны байгуулагад эмнэлзүй, эрдэм шинжилгээ, сургалт-судалгаа, эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт гээд анагаахын шинжлэх ухааны бүхий л чиглэлд амжилттай ажилласан чадварлаг эмч, багш, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн, зохион байгуулагч, төр нийгмийн нэрт зүтгэлтэн хүн билээ.

Хүмүүний нэгэн амьдралд тэр бүр ноогдоод байхгүй энэ олон албыг нэр хүндтэй хашиж явахдаа Ч. Цэрэннадмид багш маань ямагт эмч хэвээрээ үлдсэн онцгой нэгэн. Тэрээр хаа ч явсан чагнуураасаа салж үзээгүй, өргөсөн тангарагтаа үнэнч, жинхэнэ эмч хүн байлаа.

Профессор Ч.Цэрэннадмид эрдэм ухаанаараа, ажил амьдралын туршлагаараа, зан араншин, хүн чанараараа, амжилт бүтээлээрээ, нэр хүнд, зангарагаараа төр түмэндээ хүлээн зөвшөөрөгдсөн гайхалтай нэгэн байв.

Ч.Цэрэннадмид багш маань бусдаас ялгарах зан араншинтай, өөрийн гэсэн өнгө аястай, нягт нямбай, асуудлыг үндэс сууринаас нь авч ном журмын дагуу бодож, сэтгэж хийдэг. Аливаад ёс зүй, журамтай байх, ажилд эзний ёсоор хандах гэхчилэн мундаг зан чанарыг мөрдлөг болгон ажилладаг шугам шиг шулуухан ховорхон хүн-эрдэнэ. Тийм учраас Ч.Цэрэннадмид багшаар хичээл заалгуулах нь тухайн үедээ эмч оюутан залуучуудад амар хялбар зүйл огт биш байсан бөгөөд түүний шаардлагад нийцэн сурч, ажиллах нь ихээхэн хүч хөдөлмөр, тэвчээрийг шаарддаг байсан талтай ч хожмоо хэн боловч багшийн тэр арвин даалгавар, өндөр шаардлага нь мөн ч их ач тустай байсныг өгүүлж баярлаж талархах нь олонтой.

Профессор Ч. Цэрэннадмид багш бол Монголын анагаах ухаан, эрүүл мэндийн салбарт цусны эмгэг судлалын шинжлэх ухааныг үүсгэн байгуулж, энэ салбарыг эрдэм судлалынх нь хувьд, практик үйл ажиллагааных нь чиглэлд олон улсын түвшинд хүртэл хөгжүүлэхэд ухаан бодлоо зориулсан, хамтран зүтгэгч олон шавь нарынхаа хувьд уул шиг нөмөртэй, хангай шиг түшигтэй, энгийнээс энгийн, эгэлгүй ачтан нь болж чадсан эрхэм хүмүүн байв.

Багшийн маань ажил амьдралын түүх нь манай эрүүл мэндийн салбарын түүх, хөгжил дэвшилтэй холбоотой тул Монголын анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын хөгжилд профессор Ч.Цэрэннадмидын гүйцэтгэсэн үүрэг, хийж бүтээснийг хойч үедээ таниулан мөнхжүүлэх зорилгоор түүний мэндэлсний 90 насны ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд бид дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. АШУҮИС-ийн оюутны хүндэтгэлийн өргөөнд анагаахын алтан үе гэгдэх эрхэмүүдийн дунд МУ-ын ардын эмч, ЭХ-ын гавьяат ажилтан профессор Ч.Цэрэннадмидын хөргийг хүндэтгэлтэйгээр байрлуулах нь ахмад багш нарынхаа нэр хүндийг өргөж, тэднээс үлгэрлэн сайн эмч мэргэжилтэн, эрхэм үйлсийн эзэд болно гэдэгт итгэнэм.
2. Залуу эмч, судлаачидын судалгаа шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих зорилгоор МУ-ын ардын эмч, ЭХ-ын гавьяат ажилтан профессор Ч.Цэрэннадмидын нэрэмжит “Ардын эмч Ч.Цэрэннадмид” санг үүсгэн байгуулав.
3. “Монголын Дотрын анагаах ухааны хөгжил, дэвшил, цаашдын чиг хандлага ба Профессор Ч.Цэрэнннадмид” эрдэм шинжилгээ, онол практикийн хурал зохион байгуулахаар төлөвлөлөө.

Ингээд “Монголын Дотрын анагаах ухааны хөгжил, дэвшил, цаашдын чиг хандлага ба Профессор Ч.Цэрэнннадмид” эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд өөрсдийн эрдэм судлалын ажлаа эрдэм шинжилгээний тойм, өгүүлэл, илтгэл байдлаар ирүүлсэн эрхэм хүндэт эмч, багш, эрдэмтэн, судлаач та бүхнийхээ цаашдын эрдэм судлалын ажилд өндөр амжилт хүсье.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

АШУҮИС-ийн Цус судлалын тэнхимийн эрхлэгч
АУ-ны доктор, дэд профессор Ц. Одгэрэл



Монгол Улсын Ардын эмч, Эрүүлийг Хамгаалахын Гавьяат ажилтан,
Монголын Анагаах Ухааны Академийн үндэслэгч гишүүн,
Анагаах Ухааны доктор, профессор Чойжилжавын Цэрэннадмид
(1930-2017)